

ARLINGTON PUBLIC SCHOOLS

СУРГАЛТЫН АЛБА

Хүндэт эцэг эхчүүдээ:

Хэл яриа, бичгийн шалгалтыг (ХЯБШ-К) таны хүүхдээс авсан. ХЯБШ-К нь Виржиниагийн хамтын нийгэмлэгээс авдаг албан бус шалгалт юм. Энэ нь ангийн хичээл төлөвлөлтийн мэдээллээр багш нарыг хангах зорилготой. ХЯБШ шалгалт нь бүх уншигчдад тохирсон хичээлийг төлөвлөх үнэлж баршгүй мэдээллээр багш нарыг хангадаг.

Тус шалгалт нь дуу авиа болон хэвлэмэл материалын мэдлэгтэй холбоотой хэд хэдэн даалгавруудаас бүрдэнэ. Тухайлбал сурагчдаас дараах даалгаврыг гүйцэтгэх шаардсан. Даалгавар бүр тухайн ангид тавих түвшинтэй ба сонгосон даалгавруудын оноонуудыг нэгтгэн **нийлбэр оноог** гаргана.

ХЯБШ-К даалгаврууд:

- **Хослуулах мэдлэг** - Гурван багц зураг өгөх бөгөөд сурагчдаас тухайн нэг зурагтай хослох нэгийг нь сонгохыг шаардана.
- **Эхэн авианы мэдлэг** - Гурван зураг өгөх бөгөөд сурагчдаас тухайн нэг зурагтай ижил дуудлагаар эхлэх нэг зургийг сонгохыг шаардана.
- **Цагаан толгойн мэдлэг** - Сурагчдаас цагаан толгойн 26 жижиг үсгийг нэрлэхийг шаардана.
- **Үсгийн дуудлага** - Сурагчдаас /sh/ гэх мэт нэг авиагаар дуудагддаг хоёр үсэг бүхий гурван диграфаас авахуулаад 23 том үсгийн дуудлагыг хэлэхийг шаардана.
- **Үсэглэх** - cat-г /k-a-t/ гэж дуудахтай адил авиа зүйн хувьд солих боломжтой, /t-o-p/ гэх мэт гийгүүлэгч-эгшиг-гийгүүлэгч бүтэцтэй таван үгийг сурагчид үсэглэнэ.
- **Салангид үгийг таних чадвар** - Салангид үгийг таних чадвар нь ХЯБШ-К-н заавал хийх даалгавар биш боловч үүгээр сурагчдын унших чадварыг шалгах боломжтой. Урьдчилсан гарын авлага, гарын авлага болон Нэгдүгээр ангийн түвшний жагсаалтуудаар хангана.

Ерөнхий жишгийг дэд сорилуудын жишгийн хамт намар, хавар аль алинд нь тодорхойлдог. Ерөнхий жишгийг мөн нэгтгэсэн оноо гэж нэрлэдэг бөгөөд тус сурагчийн *хүрсэн байвал зохих түвшингээс доош эсвэл дээш түвшинд* байгаа эсэхийг заана. Дэд сорилын жишиг тухайн чадварт хамаарах гүйцэтгэлийн түвшинд заадаг. Багш нар уншиж бичих хичээлийг тохиромжтой арга хэлбэрээр заахдаа шалгалтаас гарсан мэдээллийг ашиглана. *Элсэлтийн түвшингийн* жишгийг хангахгүй байгаа сурагчид ХЯБШ дээр зааснаар тодорхой чадваруудыг хөгжүүлэх **нэмэлт** хичээлд сүүх болно.

Дэмжлэг үзүүлсэн танд баярлалаа.